



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ












2021/02



<http://www.ubstat.mn>



АГУУЛГА

		Хуудасны дугаар
	ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2018-2020 ОН	2
	ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	3
	НИЙГМИЙН ДААТГАЛ	4
	НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
	ЭРҮҮЛ МЭНД	6
	АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	8
	ГЭМТ ХЭРЭГ	10
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	12
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	14
	ХӨДӨӨ АЖ АХУЙ	18
	АЖ ҮЙЛДВЭР	18
	ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	22

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019	2020	2021
Шинээр төрсөн хүүхэд	тоо	691	712	742
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	569	636	276
үүнээс: эмэгтэй	хүн	311	327	149
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	444	224	250
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	438	383	347
Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт	хувь	0.5	1.3	2.0
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	2 635.3	2 762.7	2 850.0
Дүүргийн төсвийн орлого	сая төгрөг	14 545.5	17 216.3	21517.4
Дүүргийн төсвийн зарлага	сая төгрөг	11 086.1	13 618.7	10760.4



## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2021 оны 2 дугаар сард 276 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 360 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 54.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

2 дугаар сард орон тооны цомхотголоор 5, байгууллага татан буугдсанаас 1, мэргэжил, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй 1, өөр газраас шилжиж ирсэн 5, сургууль төгссөн 4, бусад шалтгаанаар 20 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 5 хүн ажилд орсноос төсөвт байгууллагад 5 хүн ажилд орсон байна.

Хүснэгт 1. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн 2 дугаар сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2019.II	2020.II	2021.II	2019.II	2020.II	2021.II
Нийт ажилгүйчүүд	569	636	276	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	284	278	141	49.9	43.7	51.1
Тусгай дунд боловсролтой	36	34	13	6.3	5.3	4.7
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	14	25	10	2.5	3.9	3.6
Бүрэн дунд боловсролтой	221	279	104	38.8	43.9	37.7
Бүрэн бус дунд боловсролтой	9	13	7	1.6	2.1	2.5
Бага, боловсролгүй	5	7	1	0.9	1.1	0.4

Зураг 1. Ажилгүйчүүд насны бүлгээр, 2021.II сард



2021 оны 2 дугаар сард 36 хүн шинээр бүртгүүлсэн байгааг ажил хайж буй шалтгаанаар нь авч үзвэл 44.4 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 30 (10.9%) нь 15-24 насны, 93 (33.7%) нь 25-34 насны, 82 (29.7%) нь 35-44 насны, 71 (25.7%) нь 45-60 насны хүмүүс байна.



## НИЙГМИЙН ДААТГАЛ

2021 оны 2 дугаар сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 3407 байгууллагын нийт 89.6 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 59626 (66.5%) нь ААНБ-ын, 9804 (10.9%) нь төсвийн байгууллагын, 5.4 мянга (6.1%) нь сайн дурын даатгуулагчид, 14.8 мянга (16.5%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2020.II	2021.II	Өсөлт, бууралт	
			тоо	Хувь
Нийт байгууллагын тоо	3631	3407	-244	93.8
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	3502	3291	-211	94.0
Төсөвт байгууллагын тоо	129	116	-13	89.9
Нийт даатгуулагчдын тоо	90502	89648	-854	99.1
ААНБ-ын даатгуулагчийн тоо	62297	59626	-2671	95.7
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	9815	9804	-11	99.9
Сайн дурын даатгуулагчийн тоо	3081	5428	2347	176.2
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	15309	14790	-519	96.6

2021 оны 2 дугаар сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 33.3 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 1.8 тэрбум төгрөгөөр (5.0%) дутуу бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан тус бүрээр, 2021 оны 2-р сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2020.II	2021.II	2020.II	2021.II	2020.II	2021.II
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	17109.4	25053.8	23079.9	21451.6	134.9	85.6
Тэтгэмжийн сангийн орлого	2759.6	1849.8	2958.2	2754.8	107.2	148.9
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	2458.7	1828.7	2770.4	2577	112.7	140.9
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	543.9	371.8	597.7	560.7	109.9	150.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	6388.1	5951.6	6388.1	5951.6	100.0	100.0
Нийт	29259.7	35055.7	35794.3	33295.7	122.3	95.0


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын (64.4%) тэтгэврийн даатгалын санд, (8.3%) тэтгэмжийн даатгалын санд, (7.7%) ҮОМШӨ-ний даатгалын санд, (1.7%) ажилгүйдлийн даатгалын санд, (17.9%) эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 3. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 16747 хүнд 16.4 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3317 хүнд 2.2 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 815 хүнд 568.6 сая төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1231 хүнд 1.8 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 958 хүнд 316.0 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 949 хүнд 2.1 тэрбум төгрөгийг, 6 хүнд оршуулгын тэтгэмж 6 сая төгрөгийг тус тус олгожээ.


ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 162 хүнд 172.4 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 19 хүнд 23.0 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 11 хүнд 23.8 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 517 хүнд 1.2 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 70.0 хувийг тэтгэврийн, 7.9 хувийг тэтгэмжийн, 1.9 хувийг ҮОМШӨ-ний, 3.8 хувийг ажилгүйдлийн, 16.4 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 4. Даатгалын сангийн орлого, зарлага сая,төг



Зураг 5. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо





## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 2 сард нийгмийн халамжийн сангийн нийт 10.9 хувь нь цалинтай ээж, 3.5 хувь хүнс тэжээл хөтөлбөрт тус тус хуваарилсан байна. Харин зарлагын 54.6 хувь нь нийгмийн халамжийн санд буюу нийт 9 031 хүнд, 9 604 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 24 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 11 194 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 4. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2021 оны II сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	4 335.4	
А. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	4 332.7	
1) Нийгмийн халамжийн сан	2 405.0	
2) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	70.9	
3) хүнс тэжээл хөтөлбөр	153.9	
4) алдарт эхийн одонгийн тусламж	1 183.9	
5) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	0.0	
6) насны хишиг	44.9	
7) цалинтай ээж хөтөлбөр	473.6	
8) өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	0.5	
Б. Хүүгийн болон бусад орлого	2.7	
а) хүүгийн орлого	2.7	
б) бусад орлого	-	
Зарлагын нийт дүн	4 254.0	46 182
1. Нийгмийн халамжийн сан	2 321.8	9 031
2. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	545.0	11 194
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1 185.7	9 604
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	2.5	24
5. Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг	153.7	7 879
6. Насны хишиг	45.3	8 450



## ЭРҮҮЛ МЭНД


Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 2 сард 250 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 26 хүнээр (11.6%), 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 0.8 продицмилээр нэмэгдсэн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 79.6 хувийг ковид 19, 8.0 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 3.2 хувийг тэмбүү, 4.8 хувийг трихомониаз, 3.2 хувийг заг хүйтэн, 1.2 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний II сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020.II	2021.II	Өсөлт, бууралт 2021/2020	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо	224	250	26	11.6
	10000 хүнд	12.3	13.1	0.8	
Вируст гепатит	Бодит тоо	0	1	1	0.0
	10000 хүнд	0	0.1	0.1	
Цусан суулга	Бодит тоо	22	0	-22	-100.0
	10000 хүнд	1.2	0	-1.2	
Улаан эсэргэнэ	Бодит тоо	4	0	-4	-100.0
	10000 хүнд	0.2	0	-0.2	
Сальмонеллөз	Бодит тоо	2	0	-2	-100.0
	10000 хүнд	0.1	0	-0.1	
Салхин цэцэг	Бодит тоо	104	0	-104	-100.0
	10000 хүнд	5.7	0	-5.7	
Гахайн хавдар	Бодит тоо	1	0	-1	-100.0
	10000 хүнд	0.1	0	-0.1	
Ёлом	Бодит тоо	0	0	0	0.0
	10000 хүнд	0	0	0	
Гар хөл, амны өвчин	Бодит тоо	11	0	-11	-100.0
	10000 хүнд	0.6	0	-0.6	
Тэмбүү	Бодит тоо	28	8	-20	-71.4
	10000 хүнд	1.5	0.4	-1.1	
Заг хүйтэн	Бодит тоо	9	8	-1	-11.1
	10000 хүнд	0.5	0.4	-0.1	
Трихомониаз	Бодит тоо	5	12	7	2.4 дах
	10000 хүнд	0.3	0.6	0.3	
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо	37	20	-17	-45.9
	10000 хүнд	2.0	1.0	-1.0	
Мөөгөнцөр	Бодит тоо	0	2	-2	0.0
	10000 хүнд	0	0.1	-0.1	
Ковид 19	Бодит тоо	0	199	199	0.0
	10000 хүнд	0	10.4	10.4	
Бусад өвчлөл	Бодит тоо	1	0	-1	-100.0
	10000 хүнд	0.1	0	-0.1	



Зураг 6. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 7. Халдварт өвчнөөр өвчлөгчид



2021 оны эхний 2 сард нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 2 хүүхдээр нэмэгдэж, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлгүй байна.

Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2019.II	2020.II	2021.II	$\frac{2021}{2020}$ %
Амаржсан эхийн тоо	687	709	733	3.4
Амьд төрсөн хүүхэд	691	712	742	4.2
Төрөхийн улмаас эндсэн эх	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	2	2	4	100
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	2	-	-	-

\*Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

\*дахин



## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2021 оны 2 дугаар сард дунджаар  $-12.4^{\circ}\text{C}$  байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс  $-1.0^{\circ}\text{C}$ -аар, олон жилийн дундажтай харьцуулбал  $4.3^{\circ}\text{C}$ -аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм  $6.4^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн хэм  $-29.2^{\circ}\text{C}$ , хур тунадасны нийлбэр 1.0 миллиметр, шороон болон цасан шуургатай 1 өдөр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7. Агаарын бохирдолт,  $\text{мг}/\text{м}^3$ , II сард<sup>1</sup>

Бодисын нэр	Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ	
Хүхэрлэг хий	SO <sub>2</sub>	0.050	367	0.499	306	0.139
Азотын давхар исэл	NO <sub>2</sub>	0.050	348	0.104	117	0.041
Тоосжилт	PM <sub>10</sub>	0.100	403	0.366	157	0.098
	PM <sub>2.5</sub>	0.050	269	0.237	148	0.063
Нүүрстөрөгчийн дутуу исэл <sup>2</sup>	CO	10.000	983	13.391	11	2.194
Озон	O <sub>3</sub>	0.100	626	0.087	-	0.030

<sup>1</sup> Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

<sup>2</sup> 8 цагийн дундаж

Хүснэгт 8. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м<sup>3</sup>, II сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл – экспо төв			Нисэх		
		2019	2020	2021	2019	2020	2021
		Мг/м <sup>3</sup>					
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	0.019	0.030	0.068	0.012	0.091	0.137
	Хамгийн их	0.041	0.087	0.163	0.027	0.226	0.251
	XXX*-с давсан хувь	-	17.0	68.0	-	87.0	96.0
Азотын давхар исэл NO <sub>2</sub>	Хэмжилтийн тоо	30	30	28	24	30	27
	Дундаж	-	-	0.035	0.019	0.033	0.040
	Хамгийн их	-	-	0	0.027	0.052	0.071
Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	XXX*-с давсан хувь	-	-	20	-	3.0	30.0
	Хэмжилтийн тоо	-	-	15	24	30	27
	Дундаж	-	-	-	-	1.362	1.506
Тоос PM <sub>10</sub>	Хамгийн их	-	-	-	-	3.845	3.795
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	Хэмжилт хийгдээгүй	-	-	-	-	90
Тоос PM <sub>25</sub>	Дундаж	0.075	0.074	0.075	0.135	0.092	0.060
	Хамгийн их	0.159	0.146	0.245	0.243	0.182	0.098
	XXX*-с давсан хувь	13.0	16.0	11.0	70.0	33.0	0.0
Озон O <sub>3</sub>	Хэмжилтийн тоо	23	25	28	23	30	27
	Дундаж	-	-	-	0.059	0.042	0.045
	Хамгийн их	-	-	-	0.093	0.073	0.083
Озон O <sub>3</sub>	XXX*-с давсан хувь	-	-	-	57.0	30.0	30.0
	Хэмжилтийн тоо	-	-	-	23	30	27
	Дундаж	0.013	0.011	0.015	0.017	0.031	0.046
Озон O <sub>3</sub>	Хамгийн их	0.029	0.030	0.032	0.025	0.076	0.083
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	90	90	81	69	90	83

- -Хүлцэх хэм хэмжээ      \*\*- CO, O<sub>3</sub> -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон  
Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2020 оны 12-р сарын танилцуулга

### Туул голын усны бохирдол:


Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны 2-р сард ковид-19 цар тахлын МХЕГ-аас байгаль орчны зөрчил илрүүлэх ажил явагдаагүй. Мөн Байгаль орчны шинжилгээний төв лабораториос туул голын усны сорьц аваагүй байна.



## ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2021 оны 2 сард 347 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 36 (9.0%) хэргээр буурсан байна.

Зураг 8. Гэмт хэргийн тоо, жил бүрийн II сард



Нийт гэмт хэргийн 49 (14.0%) нь хулгайн хэрэг, 62 (18.0%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 94 (27.0%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 12 (3.0%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 2 (1.0%) нь хүчингийн хэрэг, 2 (1.0%) нь дээрэмдэх хэрэг, 10 (3.0%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 116 (33.0%) нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, II сард

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2020 II	2021 II	$\frac{2020}{2019}$ %	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	11	12	9	1
Хүчин	4	2	-50	-2
Дээрэмдэх	4	2	-50	-2
Хулгай	89	49	-45	-40
Залилан мэхлэх	106	94	-11	-12
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	61	62	2	1
Малын хулгай	5	-	-100	-5
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	-	-	-
Хүнийг санаатай алах	1	-	-100	-1
ХАБТХАЖЭ	19	10	-47	-9
Бусад	83	116	40	33
<b>Бүгд</b>	<b>383</b>	<b>347</b>	<b>-9</b>	<b>-36</b>


\*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Нийт 49 хулгайн гэмт хэргийн 45 (92.0%) нь иргэний өмчийн хулгай, 4 (8.0%) нь халаасны хулгайн гэмт хэрэг эзэлж байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Үүнээс			Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	ХАБТХАЖЭ	Бусад
	2020 II	2021 II	Тоо	Хувь				Гэр бүлийн хүчирхийлэл	Хүчин	Хулгай	ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай					
1	17	15	-2	-12	-	1	-	-	-	4	4	-	-	-	1	-	-	9
2	45	23	-22	-49	-	-	5	-	-	3	2	-	1	1	7	-	-	7
3	50	42	-8	-16	-	1	11	1	-	9	8	-	1	1	8	-	1	11
4	36	33	-3	-8	-	-	7	-	-	5	5	-	-	-	14	-	1	6
5	3	3	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	2
6	5	8	3	60	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	2	5
7	5	4	-1	-20	-	-	1	-	-	-	-	-	-	-	1	-	1	1
8	11	15	4	36	-	-	2	-	-	2	2	-	-	-	4	-	-	7
9	13	13	-	-	-	3	5	-	-	1	1	-	-	-	2	-	-	2
10	28	17	-11	-39	-	-	2	-	1	1	1	-	-	-	5	-	2	6
11	56	37	-19	-34	-	1	5	-	1	4	4	-	-	-	10	-	1	15
12	8	5	3	38	-	-	1	-	-	1	1	-	-	-	3	-	-	-
13	3	4	1	33	-	-	3	-	-	-	-	-	-	-	-	-	-	1
14	13	8	-5	-38	-	-	-	-	-	-	-	-	-	-	5	-	-	3
15	65	46	-19	-29	-	-	6	-	-	8	7	-	1	-	14	-	1	17
16	9	21	12	133	-	2	4	1	-	4	4	-	-	-	4	-	-	7
17	2	12	10	500	-	2	2	1	-	-	-	-	-	-	4	-	-	4
18	3	8	5	167	-	1	1	-	-	1	1	-	-	-	-	-	-	5
19	4	4	-	-	-	-	1	-	-	1	-	-	1	-	-	-	-	2
20	1	18	17	17*	-	1	2	-	-	2	2	-	-	-	9	-	-	4
21	6	11	5	83	-	-	2	-	-	3	3	-	-	-	3	-	1	2
Дүн	383	347	-36	-9	-	12	62	3	2	49	45	-	4	2	94	-	10	116

Зураг 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор






## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (үрсгал орлого болон тусламжийн орлого) 2021 оны 2 дугаар сард 21.5 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 7590.9 сая төгрөгөөр (26.1%) дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2020 оноос 25.0 хувь буурсан байна. Төсвийн нийт орлогын 35.1 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 64.9 хувийг татварын бус орлого үүнээс 0.1 хувийг нийтлэг татварын бус орлого, 29.8 хувийг тусламжийн орлого, 70.1 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Зураг 10. Төсвийн орлого, зарлага, 2013-2021 онд, сая төг




Татварын орлогын хэмжээ 7.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.8 тэрбум төгрөгөөр (19.2%), татварын бус орлого 13.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 5.8 тэрбум төгрөгөөр (29.3%) тус тус дутуу бүрдсэн байна.

Хүснэгт 11. Дүүргийн төсвийн орлого, 2021 оны эхний II сард, сая.төг

Төсвийн орлого			Үүнээс:									
Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
Дүн	21517.4	73.9	-7590.9	7559.9	80.8	-1793.3	13957.5	70.7	-5797.5	6.7	8.7	-70.1

Орлогын албан татвар төлөвлөснөөс 1539.5 сая төгрөгөөр давж биелсэн бол хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 5.8 сая төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 3327.0 сая төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Зураг 11. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 12. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Хүснэгт 12. Дүүргийн төсвийн орлого, 2021 оны 2 сард, сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ хувь	Зөрүү
Орон нутгийн орлого	29108.2	21517.4	73.9	-7590.9
1.Татварын орлогын дүн	9353.2	7559.9	80.8	-1793.3
1.1 Орлогын албан татвар	4953.1	6492.6	131.1	1539.5
Хувь хүний орлогын албан татвар	4953.1	6492.6	131.1	1539.5
1.2 Хөрөнгийн албан татвар	2277.0	3303.2	145.1	1026.3
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	4381.7	1054.7	24.1	-3327.0
Улсын тэмдэгтийн хураамж	1160.0	464.6	40.1	-695.4
Ашигт малтмал ашигласны төлбөр	1.7	5.3	308.9	3.6
Газрын төлбөр	2900.0	375.1	12.9	-2524.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	320.0	209.1	65.3	-110.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	0.7	0.0	0.7
2.Татварын бус орлогын дүн	19755.0	13957.5	70.7	-5797.5
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого*	76.8	6.7	8.7	-70.1
2.2 Тусламжийн орлого	9863.3	4154.8	42.1	-5708.5
Хандив тусламж	6.8	0.0	0.0	-6.8
Төсвөөс санхүүжих	9856.5	4154.8	42.2	-5701.7
2.3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын	9814.8	9795.9	99.8	-18.8
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	9777.2	9795.9	100.2	18.8
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	37.7	0.0	0.0	-37.7

\*Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн

2021 оны 2 дугаар сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 10.8 тэрбум төгрөгийн (48.0%) зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 11.6 тэрбум төгрөгийг (52.0%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 49.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 5.9 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 9.1 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 35.6 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал түс түс эзэлж байна.

Хүснэгт 13. Дүүргийн төсвийн орлого, зарлага, 2021 оны 2 сард, сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	21517.4	22410.0	10760.4	48.0	-11651.6	10757.0

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 42.8 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд шинээр нэмэгдээгүй, 27.6 сая төгрөгөөр хасагдан, сарын эцэст нийт 15.2 сая төгрөгийн өглөгтэй байна.

Хүснэгт 14. Өглөг, 2021 оны II сард, сая.төг


	2-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	2-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	42.8	0.0	27.6	15.2



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2021 оны 2 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс өнгөрсөн сартай харьцуулахад 2.0 хувь, 2020 оны эцэстэй харьцуулахад 2.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 13. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2021 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 2.7 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 7.6 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 0.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 3.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 0.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.0 хувь, тээвэр бүлгийн үнэ 0.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 0.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 1.2 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 0.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 15. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2020-II 2019-II	2021-II 2020-II	2021-II 2020-XII	2021-II 2021-I
Ерөнхий индекс	106.9	102	102.7	102.0
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	112	109.2	107.6	105.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	103.4	104.1	100.7	100.7
Хувцас, бөс бараа, гутал	108.1	101.2	98.5	99.6
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	104.6	90.3	103.8	101.8
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.3	102.6	100.3	100.3
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	103	104.8	102	101.7
Тээвэр	101	95.3	100.6	100.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.2	100.2	100.2
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	115.2	100.7	100	100
Боловсролын үйлчилгээ	107	100.6	100	100
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	110.5	105	101.2	101.1
Бусад бараа, үйлчилгээ	105.8	105.2	100.8	100.7

2021 оны 2 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 27.9 хувийнх нь үнэ өсөж, 2.6 хувийнх нь үнэ буурч, 69.5 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.



Хүснэгт 16. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс, /**эерэг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	<b>5.4</b>	Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний үнэ 10.7 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ 7.8 хувиар, жимс, жимсгэний үнэ 2.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	<b>0.7</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд дарсны үнэ 2.4 хувиар, шар айрагны үнэ 2.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	<b>0.4</b>	Хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнийн бууралтад бүх төрлийн хувцасны үнэ 0.1 хувиар, жижиг эдлэл, хэрэгслийн үнэ 0.6 хувиар, бүх төрлийн гуталны үнэ 1.1 хувиар тус тус буурсан нь нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	<b>1.8</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хатуу түлшний үнэ 4.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	<b>0.3</b>	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн шилэн эдлэл, сав суулгын үнэ 1.3 хувиар, жижиг багаж хэрэгслийн үнэ 0.6 хувиар, гэр ахуйн барааны үнэ 0.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	<b>1.7</b>	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд эм, тарианы үнэ 2.7 хувиар өссөн нь шууд нөлөөлсөн байна.
Тээвэр	<b>0.6</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хувийн тээврийн хэрэгслийн шатах, тослох материалын үнэ 1.6 хувиар өссөн нь шууд нөлөөлөв.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	<b>0.2</b>	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнийн өсөлтөд телефон утас, факсын үйлчилгээний үнэ 0.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	<b>1.1</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд зочид гуанз, цайны газрын үнэ 2.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Бусад бараа, үйлчилгээ	<b>0.7</b>	Бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд үсчин болон гоо сайхны үйлчилгээний үнэ 1.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


2021 оны 2 дүгээр сарын 28-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Фүжи алим 2600 төгрөг, Лууван 1300 төгрөг, Сонгино 1200 төгрөг, Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 150 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 150 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 110 төгрөг, “Үхрийн мах”, ястай 100 төгрөг, Төмс 200 төгрөгөөр тус тус өссөн. “Хонины мах”, ястай 800 төгрөг, Байцаа 700 төгрөг, Цагаан будаа 525 төгрөг, Манжин 350 төгрөг, Элсэн чихэр 250 төгрөг, Задгай сүү 200 төгрөгөөр тус тус буурсан. Харин “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ тогтвортой байлаа.

Хүснэгт 17. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ\*, төгрөг, жил бүрийн II сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2020.II	2021.II	$\frac{2021}{2020}$ %
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1300	1300	100.0
Хонины мах, ястай	Кг	10000	9200	92.0
Үхрийн мах, ястай	Кг	11500	12500	108.7
Гурил, дээд зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1500	1650	110.0
Гурил, 1-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1250	1400	112.0
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	940	1050	111.7
Элсэн чихэр	Кг	2700	2450	90.7
Төмс, монгол	Кг	900	1000	111.1
Байцай, монгол	Кг	2700	2000	74.1
Лууван, монгол	Кг	1500	2800	186.7
Манжин, монгол	Кг	2600	2250	86.5
Сонгино, хятад	Кг	2800	4000	142.9
Цагаан будаа	Кг	3300	2775	84.1
Алим, фүжи	Кг	4900	7500	153.1
Сүү, задгай	литр	1800	1600	88.9
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	2530	2880	113.8

\*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв

Зураг 14. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг




Зураг 15. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 16. Нэг кг төмс, лууван, байцааны

Зураг 17. Нэг кг манжин, сонгинын дундаж үнэ, төгрөг



үнэ, төгрөг



Хүснэгт 18. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2020.II.19					2021.II.24				
	Аи 95	Аи 80	Аи 95	Аи 80	Аи 95	Аи 80	Аи 95	Аи 80	Аи 95	Аи 80
Жаст Ойл	-	1 650	-	1 650	-	1 650	-	1 650	-	1 650
Петровис	2 240	1 750	2 240	1 750	2 240	1 750	2 240	1 750	2 240	1 750
Магнай трейд	2 240	-	2 240	-	2 240	-	2 240	-	2 240	-
Сод монгол	2 240	-	2 240	-	2 240	-	2 240	-	2 240	-
Шунхлай	2 240	-	2 240	-	2 240	-	2 240	-	2 240	-
Юнигаз	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дундаж үнэ	2 240	1 700	2 240	1 700	2 240	1 700	2 240	1 700	2 240	1 700

\*Мэдээллийн эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 2-р сарын мэдээ



## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 2 сард 455 толгой мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 368 толгой малаар өссөн. Хорогдсон малын 19.3 хувь буюу 88 хээлтэгч мал хорогдсон байна.

Хүснэгт 19. Том малын зүй бус хорогдол, жил бүрийн II сард


Үзүүлэлт	2020.II	2021.II	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	87	455	-	60	76	123	196
Үүнээс: Хорогдсон хээлтэгч	14	88	-	9	12	24	43



## АЖ ҮЙЛДВЭР


Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2021 оны 2 дугаар сард 173.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 203.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 0.2 хувиар буурч, борлуулалт 1.5 хувиар өссөн байна.

Зураг 18. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2020-2021 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 103.8 тэрбум төгрөгийг дотоодод, 99.3 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 48.9 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 0.1 хувийг ундаа үйлдвэрлэл, 3.9 хувийг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэлт, 2.0 хувийг хувцас үйлдвэрлэл, 94.0 хувийг ашигт малтмалын олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 19. Үйлдвэрлэлт, 2019-2021 он, тэрбум ₮



Зураг 20. Борлуулалт, 2019-2021 он, тэрбум ₮



Хүснэгт 20. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2020 I-II	2021 I-II	$\frac{2021}{2020}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	190.0	190.0	100.0
Металлын хүдэр олборлолт	-	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	190.0	190.0	100.0
Боловсруулах үйлдвэр	143 402.0	143 614.5	100.1
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	62 268.3	59 476.4	95.5
Мах боловсруулах, консервлох	1 976.1	1 933.2	97.8
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	1 702.8	1 702.8	100.0
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7183.1	5 345.3	74.4
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6941.6	6 055.2	87.2
Малын тэжээл үйлдвэрлэл	-	-	-
Ундаа үйлдвэрлэл	44 464.7	44 439.9	99.9
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	45 929.1	45 430.3	98.9
Хувцас үйлдвэрлэл	11 804.2	11 637.2	98.6
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3 044.8	2 868.7	94.2
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 533.3	6 158.3	243.1
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл тажиллагаа	2 801.7	2 847.3	101.6
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 793.4	8 755.8	99.6
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	2 066.8	2 066.8	100.0
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	580.1	580.1	100.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	-	0.0	-
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.4	343.9	16*
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	615.0	615.0	100.0
Тавилга үйлдвэрлэл	476.1	366.9	77.1
Бусад боловсруулах үйлдвэрлэл	1 583.2	1 583.2	100.0
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	884.6	884.6	100.0
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	28 993.4	28 417.9	98.0
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	808.5	808.5	100.0
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	89.7	89.7	100.0
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	718.8	718.8	100.0
ДҮН	173 393.9	173 030.9	99.8

\*дахин

Хүснэгт 21. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2020 I-II	2021 I-II	$\frac{2021}{2020}$ %	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	190.0	129.5	68.0	94.0
Металлын хүдэр олборлолт	-	-	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	190.0	129.5	68.0	-
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	-	-	-	-
Боловсруулах үйлдвэр	170 439.2	173 332.1	101.7	6.0
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	120 785.8	129 174.5	106.9	-
Мах боловсруулах, консервлох	267.2	1430.0	5.3*	-
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	1 702.8	488.6	28.7	-
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13 388.3	23 558.1	176.0	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6 980.0	3 336.9	47.8	-
Үр тариа гурлын болон цардуул, цардууллаг		10484.3	-	-
Эзэбүтээгдэхүүн үйлдвэрлэл				
Малын тэжээл үйлдвэрлэл	-	1 118.6	-	-
Ундаа үйлдвэрлэл	98 447.5	88 758.0	40.9	0.1
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	22 010.0	8998.2	40.9	3.9
Хувцас үйлдвэрлэл	4 527.6	8698.9	192.1	2.0
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 312.1	1 028.1	44.5	-
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 533.3	6 064.6	239.4	-
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	2 462.6	1 898.7	77.1	-
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 824.5	9 833.9	111.4	-
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	2 875.7	4 066.9	141.4	-
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	580.1	748.0	128.9	-
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	-	349.4	-	-
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.4	319.9	14.9*	-
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	502.5	-	-	-
Тавилга үйлдвэрлэл	476.1	670.1	140.7	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	1 601.4	167.8	10.5	-
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	926.1	1312.8	141.7	-
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	28 993.4	28 417.9	98.0	-
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	683.8	1257.7	183.9	-
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	86.3	109.7	127.1	-
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	597.4	1 148.0	192.2	-
ДҮН	200 116.4	203 137.2	101.5	-

\*дахин

## ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2021 оны 2 дугаар сард Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 107 өргөдөл, гомдол ирснээс хуулийн дагуу хугацаанд 81 өргөдөл гомдолд хариу өгч ажиллажээ. Хуулийн хугацаанд хариу өгсөн 81, шийдвэрлэх хугацаа болоогүй 26 өргөдөл байна.

Хүснэгт 22. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга				Мэдэгдэл	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим сүлжээгээр	Гомдол	Санал	Талархал	Хүсэлт						
Удирдлага		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ТЗУХ	<b>6</b>	-	1	5	-	5	-	-	1	-	-	5	-	1	-
СТСХ		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЭЗТХ		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
НБХ		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ТНААХ	<b>38</b>	-	9	16	13	25	4	-	8	1	-	31	-	7	-
ХХҮХ	<b>5</b>	-	-	4	1	2	2	-	1	-	-	3	-	2	-
ХЗАТ	<b>4</b>	-	3	1	-	1	-	-	3	-	-	3	-	1	-
Цэргийн штаб		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>ЗДТГ-ын дүн</b>	<b>53</b>	-	<b>13</b>	<b>26</b>	<b>14</b>	<b>33</b>	<b>6</b>	-	<b>13</b>	<b>1</b>	-	<b>42</b>	-	<b>11</b>	-
ХөХҮХ	<b>8</b>	-	3	5	-	4	1	-	3	-	-	8	-	-	-
Газрын алба	<b>56</b>	-	53	1	2	1	-	-	55	-	-	49	-	7	-
Боловсролын хэлтэс	<b>3</b>	-	-	2	1	3	-	-	-	-	-	2	-	1	-
ОБХ		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хүүхэд, гэр бүл, залуучуудын ХХ	<b>7</b>	-	7	-	-	-	-	-	7	-	-	5	-	2	-
Албан бус-НТБ төв		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
МХЯХэлтэс	<b>55</b>	-	20	33	2	46	1	-	8	-	-	49	-	6	-
Татварын хэлтэс	<b>20</b>	-	20	-	-	-	-	-	20	-	-	18	-	2	-
НДХ	<b>9</b>	-	9	-	-	1	-	-	8	-	-	8	-	1	-
Цагдаагийн хэлтэс	<b>2</b>	-	-	2	-	1	-	-	1	-	-	2	-	-	-
Бүртгэлийн хэлтэс	<b>3</b>	-	-	3	-	3	-	-	-	-	-	2	-	1	-
<b>Дэргэдэх хэлтэс, албадын дүн</b>	<b>163</b>	-	<b>112</b>	<b>46</b>	<b>5</b>	<b>59</b>	<b>2</b>	-	<b>102</b>	-	-	<b>143</b>	-	<b>20</b>	-
<b>Нийт дүн</b>	<b>216</b>	-	<b>125</b>	<b>72</b>	<b>19</b>	<b>92</b>	<b>8</b>	-	<b>115</b>	<b>1</b>	-	<b>185</b>	-	<b>31</b>	-



# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2021 оны эхний 2 сар



Амаржсан эх

Төрсөн хүүхэд



2020.I-II 709

2021.I-II 733



2020.I-II 712

2021.I-II 742



Халдварт өвчнөөр  
өвчлөгчид



Бүртгэгдсэн гэмт хэрэг



2020.I-II 224

2021.I-II 250



2020.I-II 383

2021.I-II 347



Бүртгэлтэй ажилгүй иргэд



2020.II

2021.II

636

276



327



149





## Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт

Үйлдвэрлэлт, тэрбум.төг

2020.I-II **173.4**

2021.I-II **173.0**

Борлуулалт, тэрбум.төг

2020.I-II **200.1**

2021.I-II **203.1**



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт, хувь

2020.II **1.3**

2021.II **2.0**



Валютын зах зээлийн ханш

\$

1US\$ = ₮

2020.II **2762.7**

2021.II **2850.0**




Дүүргийн төсөв, сая.төг

Орлого

2020.I-II **17216.3**

2021.I-II **21517.4**



Зарлага

2020.I-II **13618.7**

2021.I-II **10760.4**

**WWW.1212.MN** СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах  
тоглоом



Валютын ханш



аппликейшнаас

**СТАТИСТИКИЙН**

**МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ**

**Data lab**

тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**



[www.facebook.com/StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)



[www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



[information@nso.mn](mailto:information@nso.mn)